УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Хяргас сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2026/111/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаангом хот<br>2026 он | Увс аймаг дахь Төрийн аудитын газар,<br>Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь<br>Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Бат-Амгалан<br>Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn<br>Аудитор: Т.Батсүх<br>Утас: 70453799, Цахим хаяг: Batsukht@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

3.5.1 Төсвийн төлөвлөлт

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

3.5.3 Нэмэлт төсөв

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

**4. АУДИТЫН ТАЙЛАН**

4.1 Ерөнхий зүйл

4.2 Материаллаг байдал

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

ХЯРГАС СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Х.ЦОГТБАЯР ТАНАА

2026.02.25 № УВА-2026/111/НА-СТА-ТШ3
танай ______ -ны № ______ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хяргас сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хяргас сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

85?505?551

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

9065555 1525010041

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **467,718,944.47** | **545,317,184.44** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **170,575,064.06** | **110,226,261.76** |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **170,575,064.06** | **110,226,261.76** |
| **3121** | **Төгрөг** | **170,575,064.06** | **110,226,261.76** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 170,575,064.06 | 110,226,261.76 |
| **33** | **АВЛАГА** | **441,060.82** | **10,939,078.64** |
| **335** | **Бусад авлага** | **441,060.82** | **10,939,078.64** |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 441,060.82 | 10,939,078.64 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **296,702,819.59** | **424,151,844.04** |
| **354** | **Хангамжийн материал** | **296,702,819.59** | **424,151,844.04** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 6,300,350.00 | 10,448,350.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 244,834,489.59 | 323,532,884.04 |
| 35440 | Түлш шатах тослох материал | 1,218,600.00 | |
| 35460 | Хүнсний материал | 19,349,380.00 | 10,185,110.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 25,000,000.00 | 79,985,500.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,162,303,899.96** | **8,742,235,025.17** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,162,303,899.96** | **8,742,235,025.17** |
| **392** | **Биет хөрөнгө** | **1,111,819,899.96** | **8,691,751,025.17** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,077,342,030.00 | 7,746,721,780.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -249,766,046.00 | -294,589,140.44 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 39,400,000.00 | 39,400,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -29,002,777.66 | -31,191,666.54 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 351,894,022.60 | 458,341,898.65 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -206,659,350.04 | -251,536,982.33 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 135,024,300.00 | 322,188,842.30 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -83,402,042.98 | -98,037,060.86 |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 00.00 | 264,917,088.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 145,557,431.50 | 621,250,410.50 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -107,669,973.26 | -125,468,149.91 |
| 39217 | Ном | 39,102,305.80 | 39,754,005.80 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **50,484,000.00** | **50,484,000.00** |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 50,484,000.00 | 50,484,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,630,022,844.43** | **9,287,552,209.61** |
| **413** | **Өглөг** | **4,163,874.10** | **54,281,823.40** |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 00.00 | 4,620,342.02 |
| **4136** | **Бусад өглөг** | **4,163,874.10** | **49,661,481.38** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 4,163,874.10 | 49,661,481.38 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,625,858,970.33** | **9,233,270,386.21** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **1,625,858,970.33** | **9,233,270,386.21** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 466,216,451.20 | 466,216,451.20 |

| | | | |
|---|---|---|---|
| 51101 | Өмч: - төрийн | 466,216,451.20 | 466,216,451.20 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **266,973,815.60** | **7,874,385,231.48** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 266,973,815.60 | 266,973,815.60 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 7,607,411,415.88 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 892,668,703.53 | 892,668,703.53 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,630,022,844.43** | **9,287,552,209.61** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**/төгрөг/**

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,604,275,679.00** | **10,490,743,529.80** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **77,322,839.00** | **7,789,858,629.80** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **77,322,839.00** | **7,789,858,629.80** |
| **120004** | **Төсөвт байгууллагын өөрийн орлого** | **3,807,300.00** | **0.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,807,300.00 | 0.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-ҮХ | 55,367,125.00 | 7,696,033,735.35 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-БМ | 18,148,414.00 | 93,824,894.45 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,526,952,840.00** | **2,700,884,900.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **2,249,726,000.00** | **2,500,265,200.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,249,726,000.00 | 2,500,265,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **00.00** | **20,000,000.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 20,000,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **277,226,840.00** | **180,619,700.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 277,226,840.00 | 180,619,700.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,550,658,674.12** | **2,883,332,113.92** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,550,658,674.12** | **2,883,332,113.92** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,462,339,506.46** | **2,779,008,433.92** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,660,417,969.28** | **1,943,852,339.10** |
| 210101 | Үндсэн цалин | 992,045,581.24 | 1,103,437,248.99 |
| 210102 | Нэмэгдэл | 546,487,638.04 | 682,681,737.99 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 48,111,134.12 |
| 210104 | Урамшуулал | 121,884,750.00 | 109,622,218.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **204,529,928.89** | **239,787,699.28** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 140,642,519.53 | 161,665,063.65 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 16,546,178.94 | 19,493,039.33 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,818,188.79 | 9,929,016.03 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 7,792,820.53 | 9,823,535.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 30,730,221.10 | 38,877,045.27 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **277,222,956.44** | **219,551,607.28** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 13,752,156.76 | 20,128,900.50 |
| 210302 | Түлш, халаалт | 261,946,199.68 | 199,422,706.78 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 1,524,600.00 | 0.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **28,604,800.00** | **30,112,150.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 280,600.00 | 5,511,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15,899,050.00 | 13,952,550.00 |
| 210404 | Ном, хэвлэлийн зардал | 40,000.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 12,385,150.00 | 10,648,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **109,015,375.00** | **168,627,100.00** |
| 210502 | Хоол, хүнс | 109,015,375.00 | 168,627,100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,946,500.00** | **2,347,300.00** |
| 210604 | Урсгал засвар | 2,946,500.00 | 2,347,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **1,113,000.00** | **0.00** |
| 210702 | Дотоод томилолтын зардал | 1,113,000.00 | 0.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **19,362,429.20** | **16,805,928.12** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,807,300.00 | 3,582,400.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 15,555,129.20 | 13,223,528.12 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **159,126,547.65** | **157,924,310.14** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,675,700.00 | 27,557,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 17,135,100.00 | 6,044,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 126,315,747.65 | 124,322,810.14 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **88,319,167.66** | **104,323,680.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **88,319,110.00** | **103,970,980.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 53,941,110.00 | 81,317,180.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 34,378,000.00 | 22,653,800.00 |
| | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **57.66** | **352,700.00** |
| 261090 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 57.66 | 352,700.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **53,617,004.88** | **7,607,411,415.88** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **53,617,004.88** | **7,607,411,415.88** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**/төгрөг/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,530,760,140.00** | **2,700,884,900.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,807,300.00** | **0.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **3,807,300.00** | **0.00** |
| **120004** | **Төсөвт байгууллагын өөрийн орлого** | **3,807,300.00** | **0.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,807,300.00 | 0.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,526,952,840.00** | **2,700,884,900.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **2,249,726,000.00** | **2,500,265,200.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,249,726,000.00 | 2,500,265,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **00.00** | **20,000,000.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 20,000,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **277,226,840.00** | **180,619,700.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 277,226,840.00 | 180,619,700.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **2,474,547,188.19** | **2,753,013,502.30** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,474,547,188.19** | **2,753,013,502.30** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,390,617,280.53** | **2,648,415,472.30** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,660,310,739.03** | **1,945,620,031.48** |
| 210101 | Үндсэн цалин | 1,012,323,570.18 | 1,103,437,248.99 |
| 210102 | Нэмэгдэл | 517,282,812.50 | 675,033,050.37 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 48,111,134.12 |
| 210104 | Урамшуулал | 130,704,356.35 | 119,038,598.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **205,078,219.96** | **243,897,682.70** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 141,500,893.09 | 165,775,047.07 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 16,230,423.85 | 19,493,039.33 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,371,264.63 | 9,929,016.03 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 7,896,947.28 | 9,823,535.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 31,078,691.11 | 38,877,045.27 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **274,280,282.34** | **177,919,700.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 13,752,156.76 | 20,128,900.50 |
| 210302 | Түлш, халаалт | 259,003,525.58 | 157,790,799.50 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 1,524,600.00 | 0.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **121,734,210.00** | **154,104,180.00** |
| 210502 | Хоол, хүнс | 121,734,210.00 | 154,104,180.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,946,500.00** | **2,347,300.00** |
| 210604 | Урсгал засвар | 2,946,500.00 | 2,347,300.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **19,202,429.20** | **32,671,500.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,807,300.00 | 3,582,400.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 15,395,129.20 | 29,089,100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **107,064,900.00** | **91,855,078.12** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 91,075,800.00 | 82,452,278.12 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 15,989,100.00 | 9,402,800.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **83,929,907.66** | **104,598,030.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **83,929,850.00** | **104,245,330.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 49,551,850.00 | 81,591,530.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 34,378,000.00 | 22,653,800.00 |
| | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **57.66** | **352,700.00** |
| 261090 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 57.66 | 352,700.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **56,212,951.81** | **-52,128,602.30** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **2,494,705.00** | **8,220,200.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **2,494,705.00** | **8,220,200.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **2,494,705.00** | **8,220,200.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 2,494,705.00 | 8,220,200.00 |
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-2,494,705.00** | **-8,220,200.00** |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **53,718,246.81** | **-60,348,802.30** |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **116,856,817.25** | **170,575,064.06** |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **170,575,064.06** | **110,226,261.76** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**/төгрөг/**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **C01** | **2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **448,356,451.20** | **892,668,703.53** | **213,356,810.72** | **1,554,381,965.45** |
| **C03** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **448,356,451.20** | **892,668,703.53** | **213,356,810.72** | **1,554,381,965.45** |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 17,860,000.00 | 00.00 | 53,617,004.88 | 71,477,004.88 |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **466,216,451.20** | **892,668,703.53** | **266,973,815.60** | **1,625,858,970.33** |
| D01 | **2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **466,216,451.20** | **892,668,703.53** | **266,973,815.60** | **1,625,858,970.33** |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 466,216,451.20 | 892,668,703.53 | 266,973,815.60 | 1,625,858,970.33 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 7,607,411,415.88 | 7,607,411,415.88 |
| **D09** | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **466,216,451.20** | **892,668,703.53** | **7,874,385,231.48** | **9,233,270,386.21** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/төгрөг/**

| ДАНС | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн |
|---|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **170,575,064.06** | **(170,575,064.06)** |
| **2** | **I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,763,409,400.00** | **2,580,614,002.30** | **182,795,397.70** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН** | **2,763,409,400.00** | **2,580,614,002.30** | **182,795,397.70** |
| **210** | **Бараа, үйлчилгээний зардал** | **2,652,985,400.00** | **2,476,368,672.30** | **176,616,727.70** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,086,035,700.00 | 1,945,620,031.48 | 140,415,668.52 |
| 210101 | Үндсэн цалин | 1,255,830,200.00 | 1,103,437,248.99 | 152,392,951.01 |
| 210102 | Нэмэгдэл | 693,656,000.00 | 675,033,050.37 | 18,622,949.63 |
| 210103 | Унаа, болон бусад нөхөн олговор | - | 48,111,134.12 | (48,111,134.12) |
| 210104 | Урамшуулал | 136,549,500.00 | 119,038,598.00 | 17,510,902.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **260,754,200.00** | **243,897,682.70** | **16,856,517.30** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 177,313,000.00 | 165,775,047.07 | 11,537,952.93 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 20,860,400.00 | 19,493,039.33 | 1,367,360.67 |
| 210203 | ҮОМШӨ ний даатгал | 10,430,100.00 | 9,929,016.03 | 501,083.97 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 10,430,100.00 | 9,823,535.00 | 606,565.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 41,720,600.00 | 38,877,045.27 | 2,843,554.73 |
| **2105** | **Нормативт зардал** | **164,107,800.00** | **154,104,180.00** | **10,003,620.00** |
| 210502 | Хоол, хүнс | 164,107,800.00 | 154,104,180.00 | 10,003,620.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр** | **32,731,100.00** | **32,671,500.00** | **59,600.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,582,400.00 | 3,582,400.00 | - |
| 210806 | Мэдээллийн технологийн зардал | 29,148,700.00 | 29,089,100.00 | 59,600.00 |
| **2201** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **109,356,600.00** | **100,075,278.12** | **9,281,321.88** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 99,904,800.00 | 90,672,478.12 | 9,232,321.88 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,451,800.00 | 9,402,800.00 | 49,000.00 |
| | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **110,424,000.00** | **104,245,330.00** | **6,178,670.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **110,424,000.00** | **104,245,330.00** | **6,178,670.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг | 87,770,200.00 | 81,591,530.00 | 6,178,670.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 22,653,800.00 | 22,653,800.00 | - |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **2,763,409,400.00** | **2,520,265,200.00** | **243,144,200.00** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **2,763,409,400.00** | **2,500,265,200.00** | **263,144,200.00** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 2,763,409,400.00 | 2,500,265,200.00 | 263,144,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **-** | **20,000,000.00** | **(20,000,000.00)** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 20,000,000.00 | (20,000,000.00) |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 170,575,064.06 | (170,575,064.06) |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 110,226,261.76 | (110,226,261.76) |

## 2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

| ДАНС | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн |
|---|---|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | - |
| **2** | **I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **180,619,700.00** | **180,267,000.00** | **352,700.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН** | **180,619,700.00** | **180,267,000.00** | **352,700.00** |
| **210** | **Бараа, үйлчилгээний зардал** | **180,619,700.00** | **180,267,000.00** | **352,700.00** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **177,919,700.00** | **177,919,700.00** | **-** |
| 210301 | Гэрэл цахилгаан | 19,840,800.00 | 20,128,900.50 | (288,100.50) |
| 210302 | Түлш, халаалт | 154,406,000.00 | 157,790,799.50 | (3,384,799.50) |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,672,900.00 | - | 3,672,900.00 |
| **2106** | **Эд хогшил худалдан авах** | **2,700,000.00** | **2,347,300.00** | **352,700.00** |
| 210604 | Урсгал засвар | 2,700,000.00 | 2,347,300.00 | 352,700.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 180,619,700.00 | 180,619,700.00 | - |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 180,619,700.00 | 180,619,700.00 | - |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 180,619,700.00 | 180,619,700.00 | - |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өөртөө итгэлтэй, амьдрах чадвартай, цаг баримталдаг, бие даасан, эх оронч, эрүүл чийрэг хүүхэд төлөвшүүлэх зорилго тавин ажиллаж байна. Нэг сургууль 10 клуб, Хүүхэд хамгааллын үйл ажиллагааг сайжруулах, сурагч бүрийг номтой нөхөрлүүлэх, ном унших дадлыг хэвшүүлэх, мэргэжлийн хөгжлийн бүлгээр тасралтгүй хөгжих хандлагыг төлөвшүүлж, ментор багш нарын манлайллыг дэмжих, цахим хэрэглээг сайжруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Хяргас сумын Ерөнхий боловсролын сургуулийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Боловсролын ерөнхий хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ хадалдан авах тухай хууль
- Хэмнэлтийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр, 07 дугаар сарын 09-ний өдөр,
- Татварын ерөнхий хуульд 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр,
- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хяргас сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хяргас сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,657,529.4 мянган төгрөгөөр буюу 569.8 хувиар өссөн байна.

***Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт***

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 170,575.0 | 110,226.3 | -60,348.7 |
| Авлага | 441.1 | 10,939.1 | 10,498.0 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 296,702.8 | 424,151.8 | 127,449.0 |
| Үндсэн хөрөнгө | 1,162,303.9 | 8,742,235.0 | 7,579,931.1 |
| **Нийт хөрөнгө** | **1,630,022.8** | **9,287,552.2** | **7,657,529.4** |
| Өр төлбөр | 4,163.8 | 54,281.8 | 50,118.0 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 1,625,859.0 | 9,233,270.4 | 7,607,411.4 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **1,630,022.8** | **9,287,552.2** | **7,657,529.4** |

Төрийн сан дахь харилцах дансны үлдэгдэл 110,226.3 мянган төгрөг болж 60,348.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Авлагын дансны үлдэгдэл 10,939.1 мянган төгрөг болж 10,498.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 441.1 мянган төгрөгийн авлага барагдаж, 10,939.1 мянган төгрөгийн авлага нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 424,151.8 мянган төгрөг болж 127,449.0 мянган төгрөгөөр өссөн нь бусад хангамжийн материал 54,985.5 мянга, хүнсний материал 240,780.0 мянга, аж ахуйн материалын зардал 91,966.2 мянга, бичиг хэргийн материал 15,431.6 мянга, түлш, шатах тослох материал 13,952.6 төгрөгөөр тус тус нэмэгдэж, тайлант онд 289,666.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 8,742,235.0 мянган төгрөг болж 7,579,931.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд сургуулийн 100 жилийн ой болсонтой холбоотой төсвийн мөнгөөр худалдан авсан болон Боловсролын ерөнхий газар, яам, ард иргэдийн хандивтай холбоотой

6,669,379.7 мянган төгрөгийн шинэ сургууль ашиглалтанд орсон, мөн машин тоног төхөөрөмж 106,447.9 мянга, тавилга хэрэгсэл 187,164.5 мянга, бусад үндсэн хөрөнгө 475,693.0 мянга, зам гүүрийн байгууламж 264,917.1 мянган төгрөгөөр тус тус өссөн нь голлон шалтгаалсан байна.

Өглөгийн дансны үлдэгдэл 54,281.8 мянган төгрөг болж 50,118.0 мянган төгрөгөөр өссөн нь ажилчидтай холбогдсон өглөг 4,620.3 мянга, байгууллагад төлөх өглөг 49,661.5 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 9,233,270.4 мянган төгрөг болж 7,607,411.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс голлон шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,767,348.7 мянга, орон нутгийн төсвөөс 180,619.7 мянган төгрөгөөр тус тус тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Улсын төсвөөс санхүүжих төсвийн төслийн саналыг 3,939.3 мянган төгрөгөөр бууруулж 2,763,409.4 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 16 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,763,409.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 180,619.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжилт олгохоор баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,500,265.2 мянга, орон нутгийн төсвөөс 180,619.7 мянга, нэмэлт санхүүжилтийн орлого 20,000.0 мянган төгрөг, нийт 2,700,884.9 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлснээс урсгал үйл ажиллагааны зардалд 2,761,233.7 мянган төгрөгийг зарцуулж, 110,226.3 мянган төгрөгийн харилцахын эцсийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,760,881.0 мянган төгрөг буюу 93.8 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 140,415.7 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 16,856.5 мянга, нормативт зардлыг 10,003.6 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 59.6 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 9,281.3 мянга, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг 6,178.7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Байр ашиглалтын үйлчилгээ /80226/ | 2,649.3 | 2,649.3 | 0 | 100% |
| 2 | Төрийн өмчийн барилгын тогтмол зардал /80111/ | 180,619.7 | 180,267.0 | 352.7 | 99.8% |
| 3 | Хүүхэд хамгаалал /80233/ | 2,918.8 | 2,782.9 | 135.9 | 95.3% |
| 4 | Сургалт семинар /80312/ | 1,555.8 | 0 | 1,555.8 | 0% |
| 5 | Эрүүл мэндийг дэмжих /81605/ | 2,900.6 | 0 | 2,900.6 | 0% |
| 6 | Үдийн цай /81801/ | 87,770.2 | 81,591.5 | 6,178.7 | 93.0% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 7 | Дотуур байр /81806/ | 552,118.9 | 481,935.8 | 70,183.1 | 87.3% |
| 8 | Хүүхдэд ээлтэй орчин /81816/ | 23,080.1 | 23,035.0 | 45.1 | 99.8% |
| 9 | Боловсролын байгууллагын багш ажилтаны мэргэжил дээшлүүлэх/81823 | 10,819.1 | 7,360.0 | 3,189.1 | 68.0% |
| 10 | Бичиг үсгийн боловсрол/81827/ | 4,063.5 | 2,414.1 | 1,649.4 | 59.4% |
| 11 | Боловсролын стандарт/81834 | 1,861,097.8 | 1,797,118.5 | 63,979.3 | 96.6% |
| 12 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа/81835/ | 178,095.0 | 146,543.5 | 31,551.5 | 82.3% |
| 13 | Сурах бичгийн түрээс /81848/ | 3,582.4 | 3,582.4 | 0 | 100.0% |
| 14 | Сургуулийн нэмэлт хөтөлбөр /81875/ | 11,395.1 | 11,335.5 | 59.6 | 99.5% |
| 15 | ЗГ болон ЗД-ын нөөц хөрөнгөөс хуваарилсан /83602/ | 20,000.0 | 19,995.5 | 4.5 | 100.0% |
| 16 | Нэмэлт /83603/ | 1,370.0 | 0 | 1,370.0 | 0.0% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5, 2.6-д харуулав.

**Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн**

/мянган төгрөг/

| № | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Программ хангамжийн бүртгэл | 3,299.6 | 3,299.6 | Conva pro, их нүүдэл зэрэг 2 программ ашиглаж байна |
| 2 | Унаа, хоолны зардал | 0 | 48,111.1 | Ажилтнуудад хоолны хөнгөлөлт 5.0 мянган төгрөгөөр тооцон олгож байна. |
| 3 | Сургалт, семинар, хурал цуглаан | 0 | 0 | Тайлант онд сургалт, семинар, хурал цуглаанд зардал гараагүй байна. |
| 4 | Гадаад томилолт, арга хэмжээ | 0.0 | 0.0 | Гадаад томилолтын зардал байхгүй байна. |
| 5 | Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал | 0.0 | 0.0 | Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна. |
| 6 | Орон тооны цомхотгол | 0.0 | 0.0 | Орон тооны цомхотгол хийгдээгүй байна. |
| 7 | Хэвлэл, мэдээлэл | 0.0 | 0.0 | Хэвлэл, мэдээллийн зардал байхгүй байна. |

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Хяргас сумын Ерөнхий боловсролын сургуулийн нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлага гараагүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Хяргас сумын Ерөнхий боловсролын сургуулийн хувьд 2025 онд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна. Үүнд: Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 134,900.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй "Дотуур байр, бага ангийн хүүхдийн хоолны хүнсний материал нийлүүлэх" тендер, мөн харьцуулалтын аргаар 64,082.9 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй "Дотуур байр, бага ангийн хүүхдийн хоолны мах махан бүтээгдэхүүн нийлүүлэх" тендерийг тус тус зарласан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Увс аймгийн Хяргас сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Батсүх гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Хяргас сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 09 дүгээр албан бичгээр ирүүлсэн.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,550,658.7 мянган төгрөгийн 1 хувиар буюу 25,506.6 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 20,405.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,883,332.1 мянган төгрөгийн 1 хувиар буюу 28,833.3 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 23,066.7 мянган төгрөгөөр тогтоосон.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Увс аймгийн Хяргас сумын Ерөнхий боловсролын сургуулийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хяргас сумын Ерөнхий боловсролын сургууль нь шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 206,486.9 мянган төгрөгийн 15 зарлагын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 7,856,220.1 мянган төгрөгийн 8 шийдвэрийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй байна. Мөн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1,454,221.0 мянган төгрөгийн 8 орлогын мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 146,525.7 мянган төгрөгийн 17 зарлагын мөнгөн гүйлгээ төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 5,282.0 мянган төгрөгийн 2 шийдвэрийн мэдээлэл, байгууллагын батлагдсан төсвийн 2,272,869.9 мянган төгрөгийн 1 мэдээлэл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний 296,582.1 мянган төгрөгийн 1 мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тус тус хугацаа хоцроон байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Хяргас сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлангийн завсрын аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 4,478.5 мянган төгрөгийн 2 алдаа, зөрчил илэрснээс 3,213.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 1,265.5 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгсөн байна. Зөвлөмжийн биелэлтийг Хяргас сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 67 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 12,238,187.7 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өглөө.

### 5.1 Зөвлөмж

*Илрүүлэлт:*

Хяргас сумын Ерөнхий боловсролын сургууль нь шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 206,486.9 мянган төгрөгийн 15 зарлагын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 7,856,220.1 мянган төгрөгийн 8 шийдвэрийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй байна. Мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1,454,221.0 мянган төгрөгийн 8 орлогын мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 146,525.7 мянган төгрөгийн 17 зарлагын мөнгөн гүйлгээ төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 5,282.0

мянган төгрөгийн 2 шийдвэрийн мэдээлэл, байгууллагын батлагдсан төсвийн 2,272,869.9 мянган төгрөгийн 1 мэдээлэл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний 296,582.1 мянган төгрөгийн 1 мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тус тус хугацаа хоцроон байршуулсан байна.

***Өгсөн зөвлөмж:***

Цаашид Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ыг хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс: Залруулсан | | Үүнээс: Залруулаагүй | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс: Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс: Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны цахим хуудаст 23 мэдээлэл байршуулаагүй, 29 мэдээлэл хугацаа хоцроон байршуулсан байна. | 1 | 12,238,187.7 | | | | | 1 | 12,238,187.7 |
| **Дүн** | **1** | **12,238,187.7** | | | | | **1** | **12,238,187.7** |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР /Т.БАТСҮХ/

9065555 1525010041

2026 оны 02 дугаар сарын 25-ны өдөр